

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН 2014 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

Комисс хуульд заасны дагуу Монгол Улс дахь хүний эрхтэй холбоотой аливаа асуудлаар судалгаа, хяналт шалгалт явуулж санал гаргах, Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж боловсруулан хүргүүлэх, хүний эрх зөрчсөн тухай гомдлыг хүлээн авч, шалгаж, шийдвэрлэх, хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих, хуулийн төсөлд санал өгөх бодлого дүн шинжилгээ хийх, хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар илтгэл УИХ-д өргөн барих, гадаад ба дотоод хамтын ажиллагааны хүрээнд дараах ажлыг 2014 онд хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАМГААЛАХ, ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1 Судалгаа, дүн шинжилгээ

Албан боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсрол олгож буй байдал судалгаа

Комиссын 2012-2014 оны Стратеги төлөвлөгөөнд тусгасан “Бүх нийтэд хүний эрхийн боловсрол олгох үндэсний тогтолцоог бэхжүүлэх”, “Албан боловсролын тогтолцоогоор олгож буй хүний эрхийн боловсролын чанар, үр нөлөөг дээшлүүлэх” зорилго, зорилтын хүрээнд албан боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсрол олгож буй үйл ажиллагаанд үнэлгээ, мониторинг хийх, энэ талаар холбогдох талуудын байр суурь, ололт амжилт, хамтын ажиллагааг тодорхойлох, нэгтгэн дүгнэх, цаашид сайжруулах зорилгоор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих үндэсний чадавхийг бэхжүүлэх” төслийн дэмжлэгтэйгээр эрх зүйч бэлтгэж буй 13 их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт “Хүний эрх” хичээл тусгагдсан эсэх, уг хичээлийн агуулга, арга зүй, үнэлгээг харьцуулан судлах ажлыг Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран хийлээ. Судалгаанд МУИС-ийн Хууль Зүйн Сургууль, Их Засаг Олон Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургууль, МҮИС-ийн Хууль Зүйн Удирдлагын Сургууль, Орхон Их Сургууль, Отгонтэнгэр Их Сургуулийн Хууль Зүйн Сургууль, Түшээ Дээд Сургууль, Улаанбаатар Их Сургууль, Үндэсний Тагнуулын Академи, Хууль Сахиулахын Их Сургууль, Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн Билэг Дээд Сургууль, Шихихутуг Хууль Зүйн Дээд сургуульта тус тус хамрагдлаа.

Судалгааг удирдамжийн дагуу дүн шинжилгээний аргачлалаар хийсэн ба эрх зүйч бэлтгэж буй их, дээд сургуулиудад хүний эрхийн боловсрол олгож буй байдал, сургалтын хөтөлбөр дэх “Хүний эрх”, түүнтэй холбоотой хичээл, сургалт, тэдгээрийн агуулга, арга зүй, хүний эрхийн сэдвийн хүрээнд хичээлийн болон хичээлээс гадуур зохион байгуулагдаж буй боловсролын хөтөлбөртэй танилцаж, улмаар дээд боловсролын түвшинд хүний эрхийн боловсролыг дэмжих талаар арга зүйн санал, зөвлөмж боловсрууллаа.

Асруулагчийн эрхийн хэрэгжилт

Төрөлжсөн асрамжийн газрын үйл ажиллагааны эрх зүйн орчныг судлах, хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд дараах асуудалд голлон анхаарч судалгааны ажлыг хяналт шалгалтын ажилтай нэгтгэн гүйцэтгэв.

Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдах иргэдийг бүрэн хамруулж чадаж буй эсэхийг судлахдаа:

- байгууллагын тоо бүртгэл, асруулагчдын жагсаалтад дүн шинжилгээ хийх;
- асрамжийн газар нь үйлчлүүлэгчийн өвөрмөц хэрэгцээ, нас, хүйсийн онцлогийг харгалзан үйлчилгээгээ нарийвчлан ангилж, төрөлжүүлж буй байдал;
- аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга хүүхэд ба иргэнийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэр гаргахдаа аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын саналыг үндэслэж буй эсэх;

- бусад өрх, иргэний хүсэлтийн дагуу төлбөртэй үйлчилгээ үзүүлдэг эсэх;
- асрамжийн газар амьдарч байгаа хүмүүсийн сэтгэл ханамжийг үнэлэх механизм ажилладаг эсэх.

Асруулагчийг хүлээн авах, шилжүүлэх, гаргахад баримтлах зарчмыг судлахдаа:

- нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталсан журамд заасны дагуу хүлээн авах, шилжүүлэх, гаргах ажиллагааг хийдэг эсэх;
- энэхүү үйл ажиллагааны сүүлийн 3 жилийн /2011-2014/ төлөв байдлыг тоо бүртгэлтэй танилцаж тогтоох.

Асруулагчийн нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр олголтыг судлахдаа:

- үйлчилгээнд хамрагдаж байгаа нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр авагч ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэний тогтоогдсон тэтгэврийнх нь 70 хувийг асруулж байгаа иргэнд, 30 хувийг тухайн асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагад олгож байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх;
- хэрэв олгож чадахгүй байгаа бол шалтгаан нөхцлийг тодорхойлох.

Хүний нөөцийн асуудлыг судлахдаа:

- байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаарх мэдээлэл;
- ажилтан, албан хаагчдын жагсаалт;
- нэг асруулагчид үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий хэдэн ажилтан ажилладаг болох;
- ажилтнуудын ажлын ачааллын талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийх.

Бусад

- асрамжийн газарт дагаж мөрдөж буй дотоод дүрэм журамд хүний эрхийн зарчмын үүднээс дүн шинжилгээ хийх;
- дүрэм, журам нь Нийгмийн халамжийн тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийх ажлыг хийж гүйцэтгэлээ.

Уг ажлыг 2014 оны 4-6, 9-10 дугаар сард үе шаттай зохион байгуулж, 21 аймгийн ахлах мэргэжилтнүүдтэй хамтран орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа бүх асрамжийн газрын талаарх мэдээллийг авч тайлан дүгнэлт, санал боловсруулаад байна.

Үйлдвэрчний Эвлэлийн байгууллагын хүний эрхийн хамгаалагчдийн эрхийн хэрэгжилт судалгаа

Монгол Улсын Их Хурлаас “Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль”-ийг 1991 онд баталж, 1993 болон 2003 онд нэмэлт, өөрчлөлт оруулан дагаж мөрдөж байгаа хэдий ч тус хуулийг хүний эрхийн хамгаалагчдын эрхийг хамгаалах тогтолцооны өнөөгийн олон улсын нийтлэг чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай байгааг үндэслэн хүний эрхийг хамгаалагчдийн эрхийн хэрэгжилтэд судалгаа хийж байна.

Судалгааны зорилго нь доорх хоёр чиглэлээр үйл ажиллагааны болон эрх зүйн баримт бичиг сайжруулах хүрээнд хийх ажлын санал, дүгнэлт, зөвлөмж гаргахад оршино. Үүнд:

- Үйлдвэрчний эвлэлийн сонгуульт ажилтны сонгуульт үүргээ гүйцэтгэх эрхийн баталгаа хэрхэн хангагдсан, цаашид юунд анхаарах, ямар зохицуулалт хэрэгтэй талаар
- Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын үйл ажиллагааны эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааны өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар.

Судалгааны ажлын хүрээнд ХБНГУ-ын Фридрих Эбертийн Сангийн дэмжлэгтэйгээр бүсчилсэн хэлбэрээр үйлдвэрчний эвлэлийн байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт 3 удаа зохион байгуулсан. Аймаг, нийслэлийн үйлдвэрчний эвлэлийн байгууллагад ажиллагсад, сонгуульт ажилтнууд болон гишүүд судалгааны ажлын үндсэн зорилтот бүлэг

байхаар сонгон авч, 21 аймаг дахь Комиссын ахлах мэргэжилтнүүд МҮЭХ-ны салбар зөвлөлтэй хамтран судалгааг гүйцэтгэлээ.

Гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар судалгааг Шүүх, Цагдаагийн байгууллагаас авсан албан ёсны мэдээлэл, орон нутгийн ажилтнуудаар дамжуулан хөдөө орон нутагт үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн талаарх кэйс мэдээлэлд үндэслэн хийлээ. Энэхүү судалгааны тайлан ХЭҮК-ын хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэлд нэг бүлэг болж орсон болно.

1.2 Хяналт шалгалт

Комисс 2014 оны төлөвлөгөөнд тусгасны дагуу 98, гомдлын дагуу 4, хамтран ажиллах саналын дагуу 28, нийт 130 объектод хяналт шалгалт зохион байгуулсан байна. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд **нийт 19 шаардлага** хүргүүлснээс гомдлын дагуу 14, хяналт шалгалтын дагуу 4, мэдээллийн дагуу 1 шаардлага хүргүүлсэн байна. Үүнээс Комиссын гишүүний 16 шаардлага биелэгдсэн, 3 шаардлага биелэгдээгүй байна. Биелэгдээгүй 3 шаардлагын 1-д нь хариу ирүүлсэн боловч хангалтгүй, 2 шаардлагад огт хариу ирүүлээгүй, шаардлагын биелэлт 84 хувьтай байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийн тухайд Комиссоос гомдлын дагуу 11, хяналт шалгалтын дагуу 11, мэдээллийн дагуу 3 **нийт 25 зөвлөмж** хүргүүлсэн байна. Үүнээс Комиссын гишүүний 20 зөвлөмж биелэгдсэн, 5 зөвлөмж биелэгдээгүй байна. Биелэгдээгүй 5 зөвлөмжийн 1-д хариу ирүүлэх хуулийн хугацаа дуусаагүй, 1 зөвлөмжид хариу ирүүлсэн боловч биелүүлээгүй, 3 зөвлөмжид огт хариу ирүүлээгүй биелэлт 80 хувьтай байна.

ШШГЕГ-ын харьяа чанга дэглэмтэй хорих 5, жирийн дэглэмтэй хорих 4, онцгой дэглэмтэй хорих 1, нийт 10 хорих анги, цагдан хорих болон эрүүлжүүлэх, захиргааны журмаар баривчлах нийт 15 байранд тус тус тусгай удирдамжийн дагуу хорих ял эдэлж буй ялтнуудын болон хорих ангид үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдын эрхийн хэрэгжилтийг үнэлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах зорилгоор Комисс хяналт шалгалт зохион байгуулсан. Комиссын гишүүний баталсан удирдамжийн хавсралтад дурдсан объектуудад хийсэн шалгалтаар илэрсэн хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн эсвэл зөрчиж болзошгүй тохиолдолд шалтгаан нөхцлийг арилгуулахаар Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүргүүлсэн байна. Үүнд:

- Өвөрхангай аймаг дахь ШШГЕГ-ын харьяа жирийн дэглэмтэй хорих 423 дугаар ангид 2014 оны 04 дүгээр сарын 11, 12-ны өдрүүдэд хорих байрны нөхцөл байдал, албан хаагч, ялтнуудын хоорондын зан байдлын талаар хийсэн шалгалтаар илэрсэн ноцтой зөрчил, дутагдалгүй. Шалгалтын дүнгийн хурлаар тус хорих ангийн удирдлагуудад цаашид анхаарч, сайжруулах асуудлыг танилцуулж, зөвлөгөө өгсөн байна.

- Ховд аймагт 2013 оны 04 дүгээр сарын 09, 10-ны өдрүүдэд Хүний эрхийн нээлттэй өдөр арга хэмжээний хүрээнд ШШГЕГ-ын харьяа жирийн дэглэмтэй хорих 457 дугаар ангид шалгалт хийж тус хорих ангид ял эдэлж буй хүмүүсийн Үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөө нь хэрхэн хангагдаж байгаа, ялтны байрны ахуй нөхцөл, эргэлт, уулзалтын байрны стандарт, хоол, хүнсний хангамж, эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж, хорих байгууллагын ажилтнуудын зан харьцаа, ялтны хувийн хэргийн бүртгэлийн байдал зэрэг нь хүний эрхийн үндсэн зарчимд хэрхэн нийцэж буйг газар дээр нь үзэж танилцах, эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүсийн хуульд заасан эрхийг баталгаатай хангуулах талаар шалгалт хийлээ.

- Төв аймгийн Баян сумд байрлах чанга дэглэмтэй хорих 415 дугаар ангид 2014 оны 5 дугаар сарын 1-ний өдөр тус ангид ял эдэлж буй хүмүүсийн эрхийн хэрэгжилтэд шалгалт хийж уг шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдал, гаргасан санал, гомдлыг үндэслэн хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, цаашид анхаарвал зохих асуудлаар шаардлага хүргүүлсэн.

-Түүнчлэн Говьсүмбэр аймгийн Чойр сум дахь чанга дэглэмтэй хорих 425 дугаар ангид 2014 оны 5 дугаар сарын 2-ны өдөр, Хөвсгөл аймаг дахь хорих 443 дугаар ангид 2014 оны 5 дугаар сарын 7, Булган аймаг дахь хорих 439 дүгээр ангид 2014 оны 5 дугаар сарын 8-9-ний өдрүүдэд, Орхон аймаг дахь хорих 437 дугаар ангид 2014 оны 5 дугаар сарын 10, Дархан-Уул аймаг дахь хорих 435 дугаар ангид 2014 оны 5 дугаар сарын 16, хорих 445 дугаар ангид 2014 оны 5 дугаар сарын 17-нд, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Дарьт дахь хорих 433 дугаар ангид 2014 оны 6 дугаар сарын 16-ны өдөр тус тус хяналт шалгалт хийлээ.

- “Хүний эрхийн нээлттэй өдөр” арга хэмжээ зохион байгуулсан 10 аймаг (Завхан, Өвөрхангай, Ховд, Увс, Баян-Өлгий, Өмнөговь, Дундговь, Хэнтий, Дорнод, Сүхбаатар), Улаанбаатар хотын 4 дүүрэг (Чингэлтэй, Баянгол, Сонгинохайрхан, Баянзүрх), Төмөр замын Цагдаагийн хэлтсийн дэргэдэх Цагдан хорих байр, захиргааны журмаар албадан саатуулах, эрүүлжүүлэх, баривчлах байранд тус тус хяналт шалгалт хийлээ.

Комисс төрөлжсөн асрамжийн нийт 21 газарт асруулагчдын эрхийн хэрэгжилтэд нарийвчилсан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт хийж нэгдсэн дүнг гаргаж байна. Дүнгийн хурлыг 2015 оны 1 сард хийхээр төлөвлөж байна. Шалгалтад Баян-Өлгий, Баянхонгор, Хөвсгөл аймгийн ахмад настны асрамж үйлчилгээний төв, Орхон аймгийн “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн харьяа Энэрэл асрамжийн төв, Ховд аймаг дахь Баруун бүсийн ХБИ-ийн нөхөн сэргээх төв, Увс аймаг дахь баруун бүсийн ахмад настны асрамж үйлчилгээний төв, Дархан-Уул аймаг дахь “СОС” хүүхдийн хотхон, “Нарны хүүхдүүд” халамжийн төв, Улаанбаатар хот дахь ахмад настны болон хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний зэрэг 21 асрамжийн газар хамрагдсан байна.

Цагдаагийн албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн асуудлаар хяналт шалгалт хийх, хуульд заасан арга хэмжээ авах хүрээнд цагдаагийн байгууллагын нийтийн хэв журам хамгаалах болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийг 4 аймгийн Цагдаагийн газар, Нийслэлийн 6 дүүрэг дэх 14 цагдаагийн хэлтсийн ажлын байрыг шалгаж, 812 алба хаагчдаас санал асуулга авч, холбогдох баримт бичигт дүн шинжилгээ хийсэн. Тус шалгалтын дүнгийн хурлыг 2015 оны 1 дүгээр сард зохион байгуулахаар товлоод байна.

Барьцаалан зээлдүүлэх төвүүдэд үйлчлүүлэгчийн өмчлөх эрхийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийх төлөвлөгөөний дагуу УБ хотын дүүргүүд дэх 33 барьцаалан зээлдүүлэх газарт санамсаргүй түүврийн аргаар сонгон авч хяналт шалгалтыг Нийслэлийн цагдаагийн газартай хамтран хийж, дүнгийн хурлыг 2014.12.05-ны өдөр төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан, барьцаалан зээлдүүлэх газрын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан. Хяналт шалгалтын болон дүнгийн хурлын тайлан, тэмдэглэл гарсан болно.

Гомдлын дагуу “Монгени” цогцолбор сургуульд суралцаж буй хүүхдүүдийн сурч боловсрох эрх (сургалтын төлбөр)-ийг зөрчиж буй асуудлаар Комисст ирүүлсэн гомдлын дагуу 2014 оны 4 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд хяналт шалгалт зохион байгуулсан. Илэрсэн зөрчлийн дагуу “Монгени” цогцолбор сургуулийн захиралд “сурагчдын сурч боловсрох, сургууль түүний орчин нөхцлийг сайжруулах, багш ажилчдын хөдөлмөрлөх эрхийн асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн зөрчлийг арилгуулах талаар Комиссын гишүүний албан шаардлага хүргүүлж шийдвэрлэсэн.

Харааны бэрхшээлтэй хүүхдүүдийн 116 дугаар сургуулийн захирал нь ажилчдаа ялгарлан гадуурхдаг, ажлын байрны дарамт үзүүлдэг, мөн хүүхдийн сурч боловсрох эрх зөрчигдөж байгаа тухай Комисст ирүүлсэн гомдлын дагуу 2014 оны 5 дугаар сарын 19-ний өдөр хяналт шалгалт зохион байгуулсан. Гомдолд дурдагдсан зөрчил тогтоогдсон бөгөөд үүний дагуу 116 дугаар сургуулийн захирал С.Э-гийн зан харьцаа, ёс зүйгүй үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ авах талаар Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүлд Комиссын гишүүний албан шаардлага хүргүүлсэн. Комиссын гишүүний албан шаардлагын дагуу тус сургуулийн захирлыг үүрэгт ажлаас нь чөлөөлж, зөрчлийг арилгуулав.

Мөн Дорнод Казакстан Улсын Их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургуулийн ажилтан, Улаанбаатар хот дахь Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын ажилтнаас ирүүлсэн хөдөлмөрлөх эрхийн зөрчлийн талаарх гомдлын дагуу хяналт шалгалт хийж Комиссын гишүүний шаардлага хүргүүлж шийдвэрлэсэн байна.

Хамтран ажиллах саналын дагуу “Орчны хүртээмж ба MNS 5682-2006, MNS 6056-2009, MNS 6055-2009 стандартууд”-ын хэрэгжилтийн үнэлгээ хийж ажлыг 28 объектод хийж дүгнэлт тайлан, санал боловсруулаад байна.

1.3 Хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, тогтолцоог боловсронгуй болгоход чиглэсэн бусад арга хэмжээ

Комиссын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг шинэчлэн боловсруулах ажлыг Ерөнхийлөгчийн тамгын газартай хамтран төслийн шинэчилсэн найруулгын талаар иргэний нийгмийн байгууллагыг оролцуулан Иргэний танхимд хэлэлцүүлэг зохион байгууллаа. Түүнчлэн Комиссын дэргэдэх Орон тооны бус зөвлөлийн гишүүдэд танилцуулж, саналыг нь авч Ерөнхийлөгчийн тамгын газарт хуулийн төслийн үзэл баримтлал, шинэчилсэн найруулгын төслийг хүргүүлэв.

"Барилгын салбар дахь аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" 167 дугаар Конвенцид нэгдэж орох асуудлаар нөлөөллийн ажил зохион байгуулав. Манай улсын эдийн засгийн хөгжилд барилгын салбарын оруулж буй хувь нэмэр ихэсч байгаатай уялдуулан хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, ажлын байрны эрүүл ахуйн асуудлаарх үндэсний бодлого, эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох, урьдчилан сэргийлэх зорилгоор ОУХБ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг дэмжих суурь тогтолцооны тухай 2006 оны 187 дугаар конвенц болон Барилгын салбар дахь аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 1988 оны 167 дугаар конвенцийг тус тус соёрхон батлах, хууль тогтоомжид зохих нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг яаралтай судалж шийдвэрлэхийг санал болгож Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын дарга, Гадаад харилцааны яам, Хууль зүйн яам, Хөдөлмөрийн яам, Барилга, хот байгуулалтын яаманд албан бичиг хүргүүлж, уг саналын дагуу Гадаад харилцааны яам болон Хөдөлмөрийн яамнаас гэрээнд нэгдэн орохыг дэмжиж байгааг илэрхийлсэн албан бичиг Комисст ирүүлсэн байна.

Хууль тогтоомж, бодлого шийдвэрийн төсөлд хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ тогтмол хийж 2014 онд нийт 20 хуулийн төсөл, 5 журмын төсөлд дүн шинжилгээ хийж, саналыг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

Үүнд:

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /шинэчилсэн найруулга/
- Гэмт хэргийн тухай хуулийн төсөл /ерөнхий анги/
- Хөдөлмөрийн тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/
- “Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах, аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”, “Нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах, хэрэглэх журам”, “Гэрч, хохирогчийн мэдээллийг нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”, “Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам
- “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протокол”-д нэгдэн орохоор гарын үсэг зурсны дагуу Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
- Өршөөл үзүүлэх тухай хуулийн төсөл
- Боловсролын тухай багц хууль /Боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай/ /шинэчилсэн найруулга/
- Согтуурч, мансуурч донтох эмгэгтэй хүнийг албадан эмчлэх тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/

- Хотыг дахин хөгжүүлэх тухай хуулийн төсөл
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл
- НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн мэдээлэл хүргүүлэх журмын тухай нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл
- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль
- Эрүүгийн процессийн багц хуулийн төслүүд /Хууль сахиулах үйл ажиллагааны тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх тухай/
- Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөл
- Төрийн байгууллага, албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг барагдуулах, нөхөн төлүүлэх журам

Үйлдвэрчний Эвлэлүүдийн эрхийн тухай хуулийг боловсронгуй болгох чиглэлээр МҮЭХ-ны төлөөлөлтэй 3 удаа уулзалт ярилцлага зохион байгуулж, нэр томъёоны ойлголт, хариуцлагын тогтолцоог тодорхой болгох, хараат бус, бие даан ажиллах нөхцөлийг бүрдүүлэх асуудал дээр нэгдсэн байр сууринд хүрсэн ба энэхүү саналыг хамтарсан судалгааны тайланд давхар тусгахаар болсон байна.

1.4 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл боловсруулах

Комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх ээлжит 13 дахь илтгэлээ боловсруулан хуулийн хугацаанд УИХ-д өргөн барьлаа. Энэ удаагийн илтгэлд хөдөлмөрлөх эрхийн асуудал, тухайлбал, барилгын салбар дахь аюулгүй ажиллагаа, цэргийн анги болон хорих анги дахь албадан хөдөлмөр, гэр бүлийн хүчирхийлэл, жендэрийн эрх тэгш байдал зэрэг дөрвөн бүлэг асуудлыг тусган хүний эрх, эрх чөлөөний асуудлаар 6 зөвлөмж хүргүүлээ.

Илтгэлийг "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 2014 оны 4 дүгээр сарын 25-ны №16 /829/-д нийтэлсэн. Мөн байгууллагын цахим хуудас www.mn-nhrc.org –ийн “Эх сурвалж” цонхны “Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл” хэсэгт ХЭҮК-ын жил бүрийн илтгэлийг байршуулж, иргэд олон нийтэд танилцах боломжийг бүрдүүлсэн. 2014 оны илтгэл-13-ийг нийт 2500 хувь монгол хэл дээр, 300 хувь англи хэл дээр ном болгон хэвлүүлж тараагаад байна.

ХЭҮК-ын Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэлийг Иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулах ажлыг 2014 оны тавдугаар сарын 21-ний өдөр Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэргэдэх Иргэний танхимд зохион байгуулж, нийт 67 хүн оролцож санал бодлоо солилцлоо. Илтгэлийг УИХ-д өргөн барьсан тухай мэдээллийг 17 хэвлэл мэдээллийн хэрэгсэл шууд сурвалжилж, илтгэлд тусгагдсан асуудал, ХЭҮК-оос өгсөн санал зөвлөмж, иргэний нийгмийн байгууллагуудын уулзалт хэлэлцүүлгийн талаарх мэдээллийг 20 орчим хэвлэл мэдээллийн хэрэгслээр 40 гаруй удаа нийтэлж, нэвтрүүлэн сурталчлаад байна.

1.5 Хүний эрх зөрчсөн тухай гомдлыг хүлээн авч, шалгаж шийдвэрлэх

2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Комисс иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 710 гомдлыг хүлээн авч ажиллагаа хийлээ.

Мөн тайлант хугацаанд нийт 1446 иргэнд 548 цагийн хууль зүйн зөвлөгөө өгснөөс нийслэлийн хэмжээнд 346 иргэнд 115 цагийн, орон нутаг дахь ахлах мэргэжилтнүүд 1100 иргэнд 433 цагийн зөвлөгөө өгч ажилласан байна.

Нийт 710 гомдлоос 330 гомдол нь ШШГЕГ-ын харьяа хорих ангиудад ял эдлэж байгаа болон сэжигтэн, яллагдагчаар цагдан хоригдож буй иргэдээс ирүүлсэн байна.

Комисст ирүүлсэн гомдлыг нутаг дэвсгэрийн харьяаллаар ангилбал Улаанбаатар хотоос 218, Хөдөө орон нутгаас 162, Улаанбаатар хот болон хөдөө, орон нутагт байрлалтай ШШГЕГ-ын

харьяа хорих ангиудаас 330, иргэний харьяаллын тухайд Монгол улсын иргэдээс 703, гадаадын иргэдээс 7 гомдол тус тус ирүүлсэн байна.

д/д	Комисст ирсэн өргөдөл гомдлыг агуулгаар авч үзвэл:	
1.	Хилс хэрэгт ял шийтгүүлсэн болон хэргийг үнэн зөвөөр шийдвэрлүүлэхийг хүссэн	134
2.	Хууль зүйн туслалцаа авахыг хүссэн	175
3.	Халдашгүй, чөлөөтэй байх эрх	31
4.	Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах, хариу авах талаар	48
5.	Газрын маргаан болон өмчлөх эрхтэй холбоотой асуудлаар	16
6.	Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах	58
7.	Иргэний харьяатын асуудлаар	11
8.	Хүүхдийн эрх зөрчигдсөн асуудлаар	18
9.	Ажлаас үндэслэлгүй халагдсан болон хөдөлмөрлөх эрх зөрчигдсөн асуудлаар	55
10	Ажлын байрны дарамт болон ялгаварлагдан гадуурхагдсан талаар	6
11	Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн талаар	24
12	Тэтгэвэр, тэтгэмж авах талаар	14
13	Эргэлт, уулзалт авах талаарх	9
14	Хохирол нөхөн төлүүлэх тухай	21
15	Батлан даалтад гарах тухай	9
16	Хорьж мөрдөх хугацаа хэтрүүлэн хорьсон тухай	20
17	Эд мөнгөний тусламж авах	16
18	Өвчний улмаас ялаас чөлөөлүүлэх	5
19	Гэр бүлийн хүчирхийллийн талаарх	9
20	Эрүү шүүлтэд өртсөн талаар	25
21	Сурч боловсрох талаар	6

Гомдлын дагуу Комисс 2014 онд нийт 3 иргэнийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргасан ба хоёр иргэний нэхэмжлэлд 84,563, 100 төгрөгийг ханган шийдвэрлүүлсэн, нэг иргэний нэхэмжлэл шийдвэрлэгдээгүй байна.

Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүхэд иргэн Д.О-ыг төлөөлөн эрүүгийн хэрэгт удаан хугацаагаар хилсээр шалгагдсаны улмаас учирсан хохирлыг арилгуулахаар 105,918,400 төгрөг нэхэмжилснээс шүүхээс Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.7 дах хэсэгт заасны дагуу Засгийн газрын нөөц сангаас 80,918,400 төгрөгийг гаргуулж иргэн Д.О-д олгохоор шийдвэрлүүлсэн.

Мөн 12 настай Э.С-ыг төлөөлөн Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 4 дүгээр шүүхэд “биеийн эрүүл мэндэд учирсан гэм хорын хохиролд 21,644,700 төгрөгийг иргэн А-гаас нэхэмжилснээс 2014.08.20-ны өдрийн анхан шатны шүүхийн шийдвэрээр иргэн А-гаас 3,644,700 төгрөгийг гаргуулж 12 настай Э.С-д олгуулахаар шийдвэрлэсэн байна.

ХОЁР. ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Тодорхой бүлэгт чиглэсэн хүний эрхийн сургалт

ХЭҮК-т шинээр томилогдсон 21 аймгийн ахлах мэргэжилтнүүдийг 2014 оны 01 дүгээр сарын 06-наас 10-ны өдүүдэд дотоод сургалтад хамруулж “Хүний эрхэд суурилсан

хандлага”-сэдвээр 40 цагийн хичээл зааж, холбогдох хууль, тогтоомж, байгууллагын дотоод дүрэм, журам, шаардлагатай ном, гарын авлагаар хангаж ажиллав. Мөн дээрх ажилтнуудад 2 дахь удаагийн сургалтаа Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 2014 оны 8 дугаар сарын 20-22-нд Батлан хамгалах яамны “Энхийг сахиулах цогцолбор”-т “Хүний эрхэд суурилсан хандлага”-сэдвээр хийж нийт 20 аймгийн ахлах мэргэжилтэн оролцлоо.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын алба хаагчдын хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хүний эрхэд суурилсан хандлага төлөвшүүлэх, үйл ажиллагаагаа хүний эрхэд суурилсан арга зүйгээр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Каритас Чех байгууллагын санхүүжилтээр Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төвлөрсөн хорих анги болон Цагдан хорих 461-р ангийг оролцуулан нийт 24 хорих ангид хүний эрхийн сургалтыг зохион байгууллаа.

ХЭҮК-оос 2014 оны 4-6 дугаар сард зохион байгуулсан уг сургалтаар нийт 161.5 цагийн сургалтыг 9 сэдвийн хүрээнд зааж, нийт 794 албан хаагч хамрагдлаа.

Сургалтын хугацаанд оролцогчдын зүгээс хичээлийн сэдэвтэй холбоотой гаргасан саналыг илтгэх хуудаст тусгаж, сэдэвт өөрчлөлт оруулалгүйгээр төлөвлөгөөт бүх сургалтыг зохион байгуулж дуусгасан болно.

Хүний эрхийн цуврал лекцийг 2014 онд “Уул уурхай ба хүний эрх”, Бодит хамгаалал-хуулийн шинэчлэл”, “Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал”, “Хүний эрхийн боловсролыг чухалчлан үзэх нь”, “Хүний эрхэд суурилсан хууль, эрх зүйн шинэчлэл”, “Хүний эрхэмсэг оршихуйг хамгаалах нь” сэдвээр 6 удаа зохион байгуулж нийт 259 хүн оролцлоо..

“Уул уурхай ба хүний эрх” сэдэвт анхны лекцийн зочноор ХБНГУ-ын Хүний эрхийн институтын дэд захирал Михаил Виндфурь оролцлоо. Энэхүү лекцийг Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгтэй хамтран 2014 оны 02 дугаар сарын 19-ны өдөр Нээлттэй нийгэм форумын хурлын танхимд зохион байгууллаа.

“Бодит хамгаалал-хуулийн шинэчлэл” сэдвээр Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн захирал Д.Энхжаргал, “Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал” сэдвээр Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэгийн тэргүүн Б.Мөнхжаргал нар тус тус лекц уншив. Цекцид ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, багш, Боловсролын их сургуулийн оюутнууд, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн төлөөлөгчид, оролцлоо. Лекцийг Нээлттэй нийгэм форумтай хамтран зохион байгуулав.

“Хүний эрхийн боловсролыг чухалчлах нь” сэдвээр НҮБХХ-ийн төслийн зохицуулагч Ч.Алтангэрэл 9 дүгээр сарын 30-ны өдөр “Хүний эрхэд суурилсан хууль, эрх зүйн шинэчлэл” сэдвээр Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх Г.Эрдэнэбат 10 дугаар сарын 30-ны өдөр тус тус лекц уншлаа. Лекцид өмгөөлөгч, хуульч, прокурор, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчид, орон тооны бус зөвлөлийн гишүүд, хууль зүйн их дээд сургуулийн оюутнууд, Тагнуулын академийн оюутнууд зэрэг нийт 87 хүн оролцлоо.

“Хүний эрхэмсэг оршихуйг хамгаалах нь” сэдвээр МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал Б.Тэмүүлэн 2014 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр илтгэл тавьж оролцов. Лекцид 68 хүн оролцлоо.

Комисст ирүүлсэн байгууллагын хүсэлт, захиалгын дагуу 2014 онд төлөвлөгөөт бус 370,9 цагийн сургалтыг 2206 хүнд, төлөвлөгөөт 115 цагийн сургалтыг 1182 хүнд, нийт 485,9 цагийн сургалтыг 3388 хүнд зохион байгуулсан байна.

А. Төлөвлөгөөт бус сургалтын бүртгэл

№	Огноо	Сургалтын сэдэв, агуулга	Оролцогчид (Байгууллага, мэргэжил, оролцогчдын тоо)	Цаг	Оролцогч дын тоо
---	-------	--------------------------	---	-----	---------------------

1	2014.01.06 -10	Дотоодын сургалт	Орон нутгийн ажилтнууд	40	21
2	2014.01.15	Хүний эрхийн үндсэн ойлголт	Сэтгүүлчид	1	30
3	2014.01.22	Хүний эрхэд суурилсан хандлага, арга зүй	ХБХНХЯ, Нийгмийн даатгал, ХХҮХ, ХТҮГ-ын газрын мэргэжилтнүүд	8	25
4	14.01.24	Хүний эрхэд суурилсан хандлага, арга зүй	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр хамтран ажиллах сайн дурын идэвхтэн гишүүд	8	35
5	2014.02.07	Хүний эрх ба төрийн үйлчилгээг сэдвийн хүрээнд Хүний эрхийн ойлголт, хандлага, гэр бүлийн хүчирхийллийн асуудлууд, жендэрийн эрх тэгш байдал	Төрийн үйлчилгээг үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллагын удирдах албан тушаалтнууд	4,5	82
6	2014.02.10	Хүний эрхийн ойлголт, хорих байгууллага, хоригдолтой харьцах наад захын жишиг дүрмүүд	ШШГЕГ-ын харьяа 409 ангийн албан хаагчдад	2	40
7	2014.02.16	Хүний эрх ба жендер	Налайх, Багануур дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид	3	20
8	2014.02.23	Хүний эрх ба жендэр	Баянгол дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид. ажилтнууд	3	19
9	2014.03.05	Хүний эрхийн ойлголт	Яаралтай тусламжийн төвийн эмч, ажилтнууд	1	80
10	2014.03.13	Комиссын үйл ажиллагааны танилцуулга	МУБИС-Нийгмийн ШУ-ны багшийн анги	1	30
11	2014.03.21	Хүний эрх ба жендэр	Чингэлтэй дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид, ажилтнууд	3	35
12	2014.03.25 -03.26	Хүний эрхэд суурилсан хандлага	Дархан Уул аймгийн Засаг даргын тамгийн газрын төрийн захиргааны болон үйлчилгээний ажилтнууд,	16	106
13	2014.03.28	Хүний эрх ба жендэр	Багахангай дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид, ажилтнууд	3	20
14	2014.04.04	Хүний эрхийн үндсэн ойлголт	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа, холбооны газар	1	18
15	2014.04.10	Хүний эрхийн зөрчил ба ХЭҮК-т гомдол шийдвэрлэх ажиллагаа, Харилцааны ёс зүй ба хүнийг эрхийг хүндэтгэх нь	Хууль сахиулах их сургуулийн хил судлалын магистрантууд	2,4	18

16	2014.04-10-2014.06.25	Хүний эрхийн үндсэн ойлголт, зарчим, Хорих ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах асуудал, Эрүү шүүлтээс ангид байх эрхийн асуудал, Хоригдлын албадан хөдөлмөрөөс ангид байх эрхийн асуудал, Онцгой зэрэглэлд хамаарах хоригдлуудын асуудал, Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх үед хүний эрхийг хангах нь, Хорих байгууллагын ажилтны ёс зүй, үүрэг хариуцлага, Жендэрт суурилсан хүчирхийлэл ба ажлын байрны бэлгийн дарамт сэдвээр	Төвлөрсөн 24 хорих ангийн болон Цагдан хорих 461-р ангийн алба хаагч, ажилтнууд	161.5	793
17	2014.04.11	"Бэлгийн цөөнхийн эрхийг хамгаалахад эмч эмнэлгийн ажилтан нарын дэмжлэг, оролцоо" сэдэвт сургалтад Хүний эрхэд суурилсан хандлага хичээл	ХӨСҮТ-ийн эмч, ажилтнууд	1	25
18	2014.04.14	Хүний эрхийн зөрчил ба ХЭҮК-т гомдол шийдвэрлэх ажиллагаа, Харилцааны ёс зүй ба хүнийг эрхийг хүндэтгэх нь	Хууль сахиулах их сургуулийн хил судлалын магистрантууд	2,5	6
19	2014.04.18	"Бэлгийн цөөнхийн эрхийг хамгаалахад эмч эмнэлгийн ажилтан нарын дэмжлэг, оролцоо" сэдэвт сургалтад Хүний эрхэд суурилсан хандлага хичээл	ХӨСҮТ-ийн эмч, ажилтнууд	1	22
20	2014.04.25	"Бэлгийн цөөнхийн эрхийг хамгаалахад эмч эмнэлгийн ажилтан нарын дэмжлэг, оролцоо" сэдэвт сургалтад Хүний эрхэд суурилсан хандлага хичээл	ХӨСҮТ-ийн эмч, ажилтнууд	1	22
21	2014.05.19	Хүний эрхийн ойлголт	ЦЕГ-ын яаралтай тусламжийн төвийн ажилтан, алба хаагчид	1	80
22	2014.06.30	Хүний эрхийн ойлголт, Хүний эрхэд суурилсан хандлага хичээл	Монголиан-Экономи сэтгүүлийн редакцийн сэтгүүлчид, ЗДТГ-ын хууль зүйн хэлтсийн хүний эрхийн мэргэжилтэн	2	4
23	14.07.07	Хүний эрхийн ойлголт, Хүний эрхэд суурилсан хандлага хичээл	Тахарын албаны шүүхийн хуягийн ажилд томилогдож байгаа ажилтнууд	2 цаг	76

24	22/08/ 2014- 20/08/2014	Хүний эрхэд суурилсан хандлага	Орон нутгийн ажилтнууд	27	20
25	14.09.26	Хяналт шалгалт явуулах Комиссын гишүүий бүрэн эрх	"Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд гадаад хяналт шалгалт хийх нь" сургалтад хамрагдаж буй ИНБ-ын төлөөлөл	1	15
26	14.10.03	Хүний эрхийн үндсэн ойлголт, хандлага	Тахарын албаны шүүхийн хуягийн ажилд томилогдож байгаа ажилтнууд	1 цаг	78
27	14.10.04	Хүний эрхийн ерөнхий ойлголт, хүний эрхэд суурилсан хандлага	Аймгуудын Хөдөлмөрийн хэлтсийн улсын байцаагч нар, сумын Засаг дарга нар	5 цаг	32
28	2014.10.06	Хүний эрхийн үндсэн ойлголт, Хүний эрхийн олон улсын гэрээг хэрэглэх нь, Хүний эрхийн зөрчил ба ХЭҮК-т гомдол шийдвэрлэх ажиллагаа, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц	Тэгш нийгэм холбоо ТББ-ын аймаг дүүргийн төлөөлөгчид	4.5 цаг	39
29	2014.10.08	Төрийн албан хаагчийн харилцааны ёс зүй ба хүний эрхийг хүндэтгэх нь	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн ажилтнууд	1.5 цаг	15
30	2014.10.09 -10.10	"Тохируулах чиг үүргийг гүйцэтгэхэд хүний эрхийн хамгаалалт"	УМХЕГ, АТГ, ЦЕГ, ХЗЯ, ШШГЕГ-ын хяналт шалгалт, мөрдөн байцаах үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтнүүд	16 цаг	24
31	14.10.23	Эрүүл мэндээ хамгаалуулах эрх	Эрүүл мэндийн шат шатны байгууллагын ажилтнууд	4 цаг	34
32	14.10.27	Хүний эрхийн Үндсэн ойлголт	Шүд, эрүү нүүрний эмгэг судлалын төвийн эмч, эмнэлгийн ажилтнууд	1 цаг	40
33	11/04- 11/06	Хүний эрхэд суурилсан хандлага	Сумдын засаг дарга, ИТХ-ын дарга нар	24	35
34	14.11.21	Хүний эрх ба төрийн үүрэг	Сангийн яамны 4 газар, 7 хэлтсийн албан хаагч, ажилтнууд	2 цаг	120
35	14.11.26	Хүний эрхийн үндсэн ойлголт, хүний эрхэд суурилсан хандлага	Тахарын ерөнхий газрын мөрдөгчид	1	20
36	11/26- 11/27	Хүний эрхийн үндсэн ойлголт, хүний эрхэд суурилсан хандлага	УЕПГ-ын аймаг, дүүрэг, тээврийн прокурорууд, орлогч прокурорууд	тус бүр 2 цаг	27 35

37	11.12-р сар	“Харилцааны ёс зүй ба хүний эрхийг хүндэтгэх нь”	“Хабу” зочид буудлын ажилтнуудад	1.5 цаг	30
38	14.12.02	Хүний эрхийн үндсэн ойлголт, хүний эрхэд суурилсан хандлага	Салбар хорооны гишүүд	3 цаг	12
39	12,18	Хүний эрхийн үндсэн ойлголт, хүний эрхэд суурилсан хандлага, жендэрийн эрх тэгш байдал, төрийн албан хаагчын харилцааны ёс зүй ба хүний эрхийг хүндэтгэх нь	Төв аймгийн Борнуур сумын ЗДТГ-ын удирдлага, ажилтнууд	5 цаг	23 хүн

“Хүний эрхийн нээлттэй өдөр” арга хэмжээний хүрээнд Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Дундговь, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн Татварын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн ажилтнууд, ИТХ, ЗДТГ-ын ажилтнууд, ЕБС, цэцэрлэгийн эрхлэгч, менежер, нэгдсэн эмнэлгийн ажилтнууд нийт 1100 гаруй албан хаагчдад 27 удаагийн сургалтаар хүний эрхийн үндсэн ойлголт, хүний эрхэд суурилсан хандлага, хүний эрхийн олон улсын гэрээг хэрэглэх нь, мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх, жендэрийн тэгш байдал, төрийн үйлчилгээ ба хүний эрх сэдвээр сургалт зохион байгуулсан. “Төрийн үйлчилгээ ба хүний эрх” сэдвийн хүрээнд иргэн төвтэй төрийн үйлчилгээ, иргэдийн хэрэгцээнд суурилсан үйлчилгээ, төрийн үйлчилгээний стандарт, ил тод байдал иргэний оролцоо, нууц хуйвалдаан, авлига, оновчтой чиг үүрэг, үр дүнд суурилсан удирдлага зэрэг агуулгаар мэдээллийг хүргэсэн болно.

Хүний эрхийн боловсрол олгох сургалтын агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүнийг боловсронгуй болгон сайжруулах ажлын хүрээнд хүний эрхийн сургагч багш нарт зориулсан гарын авлага боловсруулах ажлын төлөвлөгөө батлан уг төлөвлөгөөний дагуу “Хүний эрхийн ойлголт”, “Хүний эрхэд суурилсан хандлага, арга зүй”, “Жендэрийн тэгш байдал” зэрэг 16 сэдвээр сургалтын гарын авлагыг боловсруулах ажлыг хийлээ.

“Хүний эрх” гар утас, таблетад зориулсан аппликэшний андройд хувилбарыг албан хэрэглээнд нэвтрүүлэв.

2.2 Хүний эрхийн сурталчилгаа

“Хүний эрхийн өдөрлөг орон нутагт” арга хэмжээг 10 аймагт зохион байгуулав. Өвөрхангай аймагт 4 дүгээр сарын 7-9 нд, Завхан аймагт 4 дүгээр сарын 22-26, Баян-Өлгий, Увс, Ховд аймгуудад 5 дугаар сарын 24-6 дугаар сарын 6, Өмнөговь аймагт 2014 оны 9 дүгээр сарын 16-17-нд, Дундговь аймагт 9 дүгээр сарын 18-19-нд, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймагт 2014 оны 9 дүгээр сарын 21-нээс 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд тус тус уг арга хэмжээг зохион байгуулав. Орон нутагт төрийн үйлчилгээ үзүүлж буй байгууллага, хамт олонд хүний эрхийн сургалт явуулан төрийн болон төрийн бус байгууллага иргэдтэй нээлттэй уулзалт зохион байгуулж, орон нутгийн удирдлагаас сүүлийн 3 жил нийтээр дагаж мөрдөх шийдвэрүүдэд хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ хийж, цагдан хорих байр, болон баривчлах, эрүүлжүүлэх, байранд хяналт шалгалт хийж, иргэдээс хүний эрхийн зөрчлийн талаар өргөдөл гомдол хүлээн авах, хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулж ажиллав.

Комиссын дэргэдэх “Хүний эрхийн төлөө сэтгүүлчид”-ийн клубын гишүүдэд зориулсан 11 удаагийн уулзалт, сургалтыг зохион байгуулсан. Хүний эрхийн талаас асуудлыг хөндсөн нийтлэл нэвтрүүлэг 178-ийг бэлтгэн түгээлээ.

Хүний эрхийн олон улсын өдрийг тохиолдуулан сэтгүүлчдийн клубын 4 гишүүн 2014 оны 12 дугаар сард Архангай, Өвөрхангай, Сэлэнгэ, Булган, Дархан-Уул, Орхон 6 аймагт ажиллаж орон нутгийн хэвлэл мэдээллийн ажилтнуудад “Хэвлэн нийтлэхдээ анхаарах хүний эрхийн асуудал”, “Хүний эрх ба хэвлэл мэдээлэл” сэдэвт сургалт явууллаа.

Хүний эрхийн боловсрол, сурталчилгааны ажилд зориулж Комисс 2014 онд нийт 21 төрлийн 31469 ширхэг ном хэвлэл, тараах материалыг шинээр болон дахин нэмэлтээр хэвлэн гаргав. Үүнд: Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл /монгол, англи/ хэлээр, Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх му-ын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын холбогдох хороодоос му-ын зг-т өгсөн зөвлөмжийн эмхэтгэл (1977-2014), Хүний эрх сэтгүүл 2014/1, 2014/2, Хүний эрхийн товч тайлбар толь, Хүний эрх эмхэтгэл, Хорих байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага, Азийн хүүхдийн эрхийн 3 дугаар чуулга уулзалтын илтгэлийн эмхэтгэл, Эрүүдэн шүүхийн эсрэг тусгай илтгэгчийн тайлан, зөвлөмж, Цагдаагийн байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага, Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглал, Хүний эрхийн цуврал нийтлэл 2012, 2013, 2014 гэх мэт

"Хүний эрх" сэтгүүлийн 2014 оны 1, 2 дугаарыг хэвлүүлж олон нийтийн хүртээл болголоо. Сэтгүүлийн дугаар тус бүрт нийтлэл өгүүлэл 8, орчуулгын материал 1, зочны яриа буланд 1 ярилцлага оруулж, нийт 2500 хувь хэвлүүлсэн түгээсэн болно.

Өдөр тутмын зарим сонинд хүний эрхийн булан ажиллуулах хүрээнд Үндэсний шуудан, Зууны мэдээ, Ардчилал, Монголын үнэн сонинтай гэрээ байгуулж 2014 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс хойш Хүний эрхийн Үндэсний Комисс буланд хүний эрхийн асуудлаар комиссын ажилтнууд 50 гаруй нийтлэл бичсэн байна.

Комиссын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор "Мэдээллийн хуудас"-ын 2014 оны 1-р улирлын №41-ийг 2 дугаар сард, 2-р улирлын №42-ыг 5 дугаар сард бэлтгэн "Экимто" хэвлэлийн газарт тус бүр 2300 ширхэгийг хэвлүүлэн иргэд, олон нийтэд тараасан байна. Тус хуудаст Комиссын 3 үндсэн чиг үүргийн дагуу үйл ажиллагааны тайланг тоймлох, үр дүнг илтгэх хэлбэрээр мэдээллийг бэлтгэн нийтэлж байгаа болно.

Хүний эрхийн Олон Улсын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд "Хэвлэл мэдээлэл ба хүний эрх" сэдэвт аян зохион байгуулж Монголын Сэтгүүлчдийн Эвлэлтэй хамтран хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн дунд 2014 оны 11 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд "Хүний эрхийн хамгаалагч" сэдвээр шилдэг нийтлэл, нэвтрүүлгийн уралдаан зарлаж шалгарууллаа. Уралдаанд нийт 16 оролцогчийн 18 бүтээл ирүүлснээс сайт болон сонины нийтлэл-16, телевиз радиогийн нэвтрүүлэг тус бүр нэг байлаа. Шүүгчид бүтээл бүртэй нэг бүрчлэн танилцаж, дараах дүнг гаргав. Үүнд:

Нийтлэлийн төрөлд: 1-р байранд "Бамбайгүй хамгаалагчид" нийтлэлээрээ "Монголын үнэн" сонины сэтгүүлч Б.Цэцэгдэлгэр, 2-р байр "Монгол хүний хөдөлмөрлөх эрхийг хамгаалъя" цуврал 4 нийтлэлээр "24 цаг" сайтын сэтгүүлч Д.Идэржаргал, 3-р байр "Болзооноос болгоомжил" нийтлэлээрээ "Өнөөдөр" сонины сэтгүүлч Э.Эрдэнэцэцэг;

Теле нэвтрүүлгийн төрөлд

1,2-р байрыг шалгаруулах хэмжээний өрсөлдөхүйц тооны бүтээл ирээгүй тул шүүгчдийн саналаар байр эзлүүлэхийг түдгэлзэв. 3-р байр, Өнөөдөр ба ирээдүй-Хүрдний хүүхдүүд нэвтрүүлэгээр Эх орон телевизийн сэтгүүлч Д.Байгал,

Радио нэвтрүүлгийн төрөлд

Мөн өрсөлдөхүйц тооны бүтээл ирээгүй тул шүүгчдийн саналаар 1,2-р байр эзлүүлэхийг түдгэлзэж, 3-р байранд, "Сэтгүүлчид хүний эрхийг хамгаалах нь" радио нэвтрүүлгээрээ МҮОНР-ийн Хурд агентлагийн сэтгүүлч Л.Алтанхишиг нар тус тус шалгарлаа.

Комиссоос хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих, хүндэтгэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх утга агуулга илэрхийлсэн "Хүний эрхийн тусгал" сэдэвт гэрэл зургийн уралдааныг 2014 оны 11 дүгээр сарын 12-ноос 12 дугаар сарын 3-ны өдрийг хүртэлх хугацаанд мэргэжлийн гэрэл зурагчид, гэрэл зураг сонирхогчдын дунд зарлаж шалгарууллаа. Уралдаанд нийт 19 оролцогчийн 163 бүтээл ирснээс:

- Нэгдүгээр байр: Г.Өнөболд "Төр өөрийгөө ялсан" бүтээлээр

- Хоёрдугаар байр: Д.Давааням “Өнгөрсөн, ирээдүйн зааг” бүтээлээр
- Гуравдугаар байр: М.Нямсайхан “Аав аа, архи битгий уугаач” бүтээлээр
- Тусгай байр: тус бүр 26 бүтээл шалгарч, өргөмжлөл, мөнгөн шагнал гардуулав.
Уралдаанд шалгарсан бүтээлийг цаашид хүний эрхийн сургалт, сурталчилгаанд ашиглах юм.

2014 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 11 цагт ХЭҮК өөрийн байрандаа Хүний эрхийн Олон Улсын өдөрт зориулсан Хэвлэлийн бага хурлыг зохион байгуулж, 33 хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл оролцлоо.

Хэвлэлийн бага хурлын үеэр Комиссын дарга, гишүүд ХЭҮК-оос 2014 онд хэрэгжүүлсэн томоохон үйл ажиллагаа, олон талт хамтын ажиллагааны хүрээнд хийгдсэн ажлын талаар товч мэдээлэл өгч, шилдэг нийтлэл, нэвтрүүлэг, гэрэл зургийн уралдааны дүнг олон нийтэд танилцуулж, шагнал гардуулах ёслолын ажиллагааг зохион байгуулав. Мөн НҮБХЭДКГ-ын илгээлт, Комиссын даргын мэндчилгээ, хэвлэлийн мэдээ, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, “Хүний эрх” эмхэтгэлийг оролцогчдод тараав.

Комиссын дарга Ж.Бямбадорж 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдөр МҮОНТВ-ээр “Хүний эрх ба Үндсэн хууль” теле лекц уншиж, дарга, гишүүд UBS телевизийн “Цай юу, кофе юу” шууд нэвтрүүлэгт зочноор орж, ярилцлаа.

Мөн МҮОНТВ-ийн “Нээлттэй хэлэлцүүлэг” нэвтрүүлэгт Комиссын гишүүн П.Оюунчимэг зочноор уригдаж ярилцлага өгөв.

Хүний эрхийн Олон Улсын өдрөөр МҮОНТВ-ийн 2 дугаар суваг “Хүний эрхийн төлөөх үйлс” ХЭҮК-ын захиалгат нэвтрүүлэг, “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс”, “Хүний эрхийн боловсрол хүн бүрт хэрэгтэй” зэрэг шторкийг олон нийтийн хүртээл болголоо.

2014 оны 12 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан “Хүний эрхийн өдөрлөг” арга хэмжээг 5 телевиз сурвалжилсан бол ШШГЕГ, УЕПГ, Хууль сахиулахын дээд сургуульд ном гардуулах ажиллагааг МҮОНР, “Шинэ Монгол” радио сурвалжиллаа.

Комиссын цахим хуудаст ХЭҮК-ын даргын мэндчилгээ, НҮБ-ын ХЭДКГ-ын илгээлт, Хүний эрхийг хамгаалагчдын тухай зарим баримт бичиг, Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглал, Хүний эрхийн Олон Улсын өдрийн тухай энэ өдрийг Монгол Улсад тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг мэдээллийг багтаасан хуудсыг шинээр нээлгэсэн байна.

Мөн Хүний эрхийн олон улсын өдрийг угтаж дараах арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Үүнд:

- Хүний эрхийн боловсролыг түгээх нь арга хэмжээ –Үндэсний Номын сантай;
- Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн хэрэгжилт Монгол Улсад” конвенцийн 30 жилд зориулж онол практикийн бага хурал Эмнести Интернэшнлтэй;
- Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг хуяглан хүргэх автомашин, тусгай хэрэгслийг олон нийтэд танилцуулах ажиллагааг Тахарын Ерөнхий газраас Комисстой;
- Хууль сахиулах чиглэлээр төрийн байгууллагатай санамж бичиг шинэчлэн болон хугацааг сунган үргэлжлүүлэн байгуулах ажиллагааг ЗХЖШ, ЦЕГ, ШШГЕГ, ТЕГ-тай;
- Орон нутагт хүний эрхийн олон улсын өдрийг тэмдэглэх удирдамжийг батлан хүргүүлж, бүх аймгийн ахлах мэргэжилтнүүд аймаг орон нутгийнхаа хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад зориулсан Хэвлэл мэдээлэл ба Хүний эрх сэдэвт сургалт зохион байгууллаа.
- Сэтгүүлчдийн клубын гишүүд орон нутагт ажиллаа.
- Хүний эрхийн төлөө залуучуудын клубын гишүүд ЕБС-ын 4 дүгээр дунд сургууль дээр Хүний эрхийн өдөрлөг зохион байгууллаа.

- Хүний эрх ба Үндсэн хууль теле лекц-д Комиссын дарга Ж.Бямбадорж, хууль эрх зүйн чиглэлээр суралцдаг оюутнууд оролцож, МҮОНТВ-ээр 10-ны өдөр шууд нэвтрүүлээ.
- ИНБ-уудын ээлжит 9 дэх уулзалтыг тус тус зохион байгууллаа.

Жич: Хүний эрхийн олон улсын өдөртэй холбоотой үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлан тусдаа гарсан болно.

Комиссын мэдээллийн санг ажилтнууд болон олон нийтэд нээлттэй ажиллуулж тус мэдээллийн сангаас давхардсан тоогоор 64 хүн үйлчлүүлсэн байна. Тэдэнд шаардлагатай ном товхимол, Комиссын хэвлүүлсэн шинэ хэвлэлийн талаарх мэдээлэл өгч, ажиллалаа. Энэ хугацаанд Комиссын мэдээлэл лавлагааны төвд шинээр 22 ном бүртгэж авсан байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулах ажлын хүрээнд “Зууны мэдээ”, “Үндэсний шуудан” сонинтой хамтын ажиллагааны гэрээг үргэлжлүүлэн хийж, шинээр “Ардчилал”, “Монголын Үнэн” сонинтай гэрээ байгуулан хамтран ажиллав.

Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлтэй хамтран ажиллах Санамж бичгийг 2014 оны 2 дугаар сарын 21-нд 2 жилийн хугацаатай байгуулав. Тус Санамж бичгийн хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн эрхийг хамгаалах чиглэлээр хамтран ажиллахаар боллоо.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасны дагуу ХЭҮК-ын үйл ажиллагааны мэдээллийг тухай бүр шинэчилж, агуулгыг баяжуулан “Мэдээллийн ил тод байдал” буланг шинээр нээж, төсөв санхүү, үйл ажиллагаа, хүний нөөцийн ил тод байдлын талаарх мэдээ мэдээллийг байршуулав. Мөн ХЭҮК-ын цахим хуудас, олон нийтийн сүлжээг хөтлөн явуулах журмыг батлан хэрэгжүүлж 2014 оны байдлаар Комиссын www.mn-nhrc.org албан ёсны цахим хуудаст нийт 140 орчим гэрэл зураг, 85 орчим мэдээ, мэдээллийг шинээр нэмж байршууллаа. Мөн ХЭҮК-ын олон нийтийн сүлжээ буюу www.youtube.com/mn-nhrc.org хаягт ХЭҮК-ын дэргэдэх клубын гишүүн сэтгүүлчдийн бүтээл болон ХЭҮК-оос захиалан хийлгэсэн нэвтрүүлэг, уулзалт лекц зэрэг нийт 71 дүрс бичлэгийг байршуулан олон нийтэд хүргээд байна.

Түүнчлэн ухаалаг гар утас, төхөөрөмж ашиглагчдад зориулсан "Хүний эрх" аппликэйшнийг Комиссын цахим хуудас, олон нийтийн сүлжээнд байршууллаа.

2014 онд ХЭҮК-ын гомдол шийдвэрлэх ажиллагаа, орон нутаг дахь хүний эрхийн үйл ажиллагаа, иргэдийн хөдөлмөрлөх эрх, жендэрийн тэгш байдал, хохирогчийн эрх, ХЭҮК-ын төлөөлөн нэхэмжлэл, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, гэр бүлийн хүчирхийлэл, хохирогчдын эрх, гэр, хохирогч хамгаалал, ялтны эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрх, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл, амьд явах эрх, хүүхдийн эрх, үндэсний цөөнхийн эрхийн хэрэгжилт зэрэг сэдвээр МҮОНТВ, UBS, ТВ9, Ийгл, Стар, Монгол HD, ТВ5 зэрэг 12 телевиз, www.news.mn, www.gogo.mn, www.info.mn зэрэг мэдээллийн 9 сайт, “Үндэсний шуудан”, “Өдрийн сонин”, “Зууны мэдээ” зэрэг 7 сонин, Улаанбаатар, Монголын радио зэрэг нийт 30 орчим хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийт 207 удаа ХЭҮК-ын дарга, гишүүд, Ажлын албаны дарга, ажилтнууд ярилцлага, мэдээлэл өгч ажиллав.

Комиссын сурталчилгааны самбаруудыг шинэчлэн 204*120 хэмжээтэй 2 самбар, 150*120 хэмжээтэй 3 самбар, 204*120 хэмжээтэй Монгол Улсын газрын зураг, 100*120 хэмжээтэй нийслэлийн 9 дүүргийн газрын зургийн хамт нийт 5 самбар, 2 газрын зургийг 5 өнгийн 100 ширхэг магнеттайгаар хийлгэж байршуулж, хэлтсүүд үйл ажиллагааны болон санхүүгийн холбогдох мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.

Хууль тогтоомжийн дүн шинжилгээ, хүний эрхийн боловсрол, мэдээллийн цогц сан бий болгох ажлын хүрээнд Комиссын дотоод үйл ажиллагааг бүрэн цахимжуулахаар шийдвэрлэж “Эйбл софт” компанийн боловсруулсан e-office программыг нэвтрүүлээд байна.

Мэдээллийн сангийн бүртгэлд хууль тогтоомжийн дүн шинжилгээний бүртгэлийг тогтмол хөтөлж, цаг хугацаандаа мэдээлэл оруулж хэвшлээ.

ГУРАВ: ЗАХИРГАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

3.1 Гадаад хамтын ажиллагаа

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1993 онд баталсан Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын талаарх Парисын зарчимд нийцсэн хараат бус, бие даасан, үндэсний байгууллага билээ. Үүнийг илэрхийлж Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Олон улсын Зохицуулах Хорооноос Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст 2003, 2008 онд “А” статус олгосон байдаг. Магадлан итгэмжлэлийг 5 жил тутам хийдэг бөгөөд 2014 оны 10 дугаар сарын 28-ны өдөр болсон Магадлан итгэмжлэх дэд хорооны ээлжит хурлаар Комиссыг дахин “А” үнэлгээтэйгээр магадлан итгэмжлэх зөвлөмж гаргалаа. Энэ ажлын хүрээнд бэлтгэл ажлыг хангаж, ээлжит хурлаар Комиссын асуудал орох үед Комиссын дарга, гишүүд, Ажлын албаны дарга холбогдох ажилтнууд утсаар оролцож Дэд хороог мэдээллээр хангаж ажиллав.

Япон улсын Токио хотод 2014 оны 1 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Зүүн Ази дахь Хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаарх Симпозиумд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Бямбадорж, Ажлын албаны дарга А.Дашдэлэг нар Монголын хүүхдийн эрхийн асуудлаар илтгэл тавьж оролцлоо. Симпозиумоор бүсийн хэмжээнд хүүхдийн эрхийг хамгаалах бие даасан Комисс байгуулан ажиллуулах, НҮБ-ын Хүүхдийн сангаас санаачилсан “Хүүхдэд ээлтэй хот” бий болгох зэрэг асуудлыг хэлэлцсэн байна. Симпозиумоос хүүхдийн эрхийн асуудлаарх Азийн III чуулганыг Монгол Улсад зохион байгуулахаар шийдвэрлэж тус Чуулга уулзалтыг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө Үндэсний газар, НҮБ-ын Хүүхдийн сангийн Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар, Япон Улсын Хүүхдийн эрхийн Конвенцийн Институц хамтран Улаанбаатар хотноо 2014 оны 8 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Азийн улс орнууд үндэсний болон орон нутгийн түвшинд хүүхдийн эрхийг хамгаалах талаар гаргаж буй хүчин чармайлт, ололт амжилт, туршлагаа харилцан солилцох, тулгамдаж буй бэрхшээл, цаашдын чиг хандлага, хамтын ажиллагааг тодорхойлох зорилготой тус чуулга уулзалтад Япон, Солонгос, Энэтхэг, Камбож, Индонези зэрэг Зүүн Азийн орнуудаас 40 гаруй төлөөлөгч хүрэлцэн ирж, нийт 160 гаруй хүн оролцлоо. Чуулганд оролцогчдоос хүүхдийн эрхийг хамгаалах талаар Тунхаглал гаргасан болно. Чуулганд тавьсан илтгэлийг эмхэтгэн хэвлүүлж, олны хүртээл болгоод байна.

Швейцарь Улсын Женев хотноо 2014 оны 3 дугаар сарын 12-14-нд болсон Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын олон улсын Зохицуулах Хорооны ээлжит XXVII хуралд Комиссын дарга тэргүүтэй төлөөлөгчид оролцлоо. Хүний эрхийн үндэсний байгууллагуудын олон улсын зохицуулах хорооны энэ удаагийн хурлаар тус хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлах, санхүүгийн тайлагналт, ХЭҮБ ба парламент хоорондын харилцаа, хүний эрхийн талаарх үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөө, ОУЗХ-ны магадлан итгэмжлэх үйл ажиллагааны явц зэрэг асуудлыг авч хэлэлцсэн байна. Хурлын үеэр Комиссын дарга Ж.Бямбадорж ОУЗХ-ны болон Ази Номхон далайн бүсийн ХЭҮБ-ын чуулганы Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газрын удирдлага, ажилтнуудтай уулзаж, хамтын ажиллагааны хүрээнд хэд хэдэн үйл ажиллагаа явуулахаар тохиролцсон байна.

АНУ-ын Төрийн Департаментын Боловсрол болон соёлын асуудал эрхэлсэн газраас зохион байгуулсан "Хүний эрх болон олон нийт" Зүүн Ази болон Номхон далайн орнуудын төлөөлөгчдийн манлайллын хөтөлбөрт Комиссын гишүүн П.Оюунчимэг 2014 оны 1 дүгээр сарын 27-ноос 2 дугаар сарын 14-ний өдрүүдэд оролцож, АНУ-ын 5 мужид айлчлан харилцан туршлага солилцов.

Энэтхэг улсад болсон Бизнес ба хүний эрхийн тухай баримт бичгийн үндэсний хэрэгжилтийн асуудлаарх Ази Номхон Далайн бүс нутгийн хэлэлцүүлэгт Комиссын дарга

2014 оны 4 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд оролцов. Тус уулзалтаар НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн баримтлах зарчим болон бизнесийн үйл ажиллагаан дахь хүний эрхийн бусад баримт бичгийг хэрэгжүүлэх үндэсний стратегийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх асуудлыг авч хэлэлцсэн байна.

Европын аюулгүй байдал ба хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн газраас 2012 онд орос хэлээр эрхлэн гаргасан "Эмэгтэйчүүдийн эрх ба жендэрийн тэгш байдал" хүний эрхийн үндэсний байгууллагуудад зориулсан гарын авлага номыг Комиссын дарга Ж.Бямбадорж монгол хэлнээ орчуулан хэвлүүлж 2014 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр энэ чиглэлээр ажилладаг байгууллагын төлөөлөгчдөд танилцуулах уулзалтыг зохион явуулав. Ном танилцуулах арга хэмжээнд номын зохиогч ЕАБХАБ-ын төлөөлөл өөрийн биеэр хүрэлцэн ирж талархалаа илэрхийлж оролцлоо.

АНДЧ-ны 2015-2020 оны Стратеги төлөвлөгөө боловсруулахтай холбогдуулан АНДЧ-ны Ажлын албанаас ирүүлсэн гишүүн байгууллагын нөхцөл байдлын дүн шинжилгээ 28 хуудас асуумжид хариулав. Энэ ажлын хүрээнд ажилтнуудыг 3 бүлэгт хуваарилан workshop зохион байгуулж бүлэг тус бүрийг асуулга дээр ажиллуулав. Үр дүнг 5 дугаар сарын 23-нд нэгтгэн хянаж, эцсийн хувилбарыг 5 дугаар сарын 30-нд, мөн АНДЧ-ны гишүүн байгууллагын мэдээлэл шинэчлэх судалгааны асуумж бөглөж Чуулганы Ажлын албанд илгээв.

НҮБ-ын ХЭДКГ-ын Албадан баривчлах асуудлыг хариуцсан Ажлын хэсгээс ирүүлсэн санал асуулгыг орчуулж, ГХШХ-т хүргүүлж, санал асуулгын хариултыг авч орчуулж хүргүүлэх, АРФ-с ирүүлсэн төслийн санал болон хүний эрхийн асуудлаарх мэдээлэл, судалгааны асуулга хүргүүлэх, ОУЗХ-ны Магадлан итгэмжлэх дэд хорооны зөвлөмжтэй холбогдуулан Комиссоос явуулсан тайлбар, хариу өгөх ажлууд хийгдлээ.

2014 онд ХЭҮК-т дараах гадаадын зочид төлөөлөгчид хүрэлцэн ирж, Комиссын дарга, гишүүдтэй уулзалт хийн, цаашдын хамтын ажиллагааны чиглэлээр санал солилцсон байна. Үүнд:

-Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын урилгаар Хүүхдийн эрхийн Азийн форумын удирдах зөвлөлийн дарга, Хүүхдийн эрхийн Конвенцийн судалгааны институцийн ерөнхий захирал, ноён Акито Кита, Хүүхдийн эрхийн Азийн форумын удирдах зөвлөлийн ерөнхий нарийн бичгийн дарга, ноён Шигето Арамаки, Тоёо их сургуулийн профессор, хатагтай Токо Учида нар 2014 оны 4 дүгээр сарын 29-нөөс 5 дугаар сарын 01-ний өдөр айлчилж, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилт, нөхцөл байдлын талаар холбогдох байгууллагын удирдлагуудтай уулзлаа.

-НҮБ-ын Хүүхдийн сангийн Монгол Улс дахь суурин төлөөлөгч Мухамед Фолл Маликтай уулзаж Азийн Хүүхдийн эрхийн III форумыг Улаанбаатар хотноо зохион байгуулах бэлтгэл ажлын талаар санал солилцов. НҮБХС-ийн захирал ноён Мухамед Фоллыг Хүний эрх хүндэт тэмдэгээр шагнаж урамшуулав.

-Европын Холбооны Бээжин дэх төлөөлөгчийн газрын 1-р нарийн бичгийн дарга 3 дугаар сарын 26-ны өдөр ирж Комиссын дарга, гишүүдтэй уулзан Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн 2 дахь шатнаас өмнөх МУ-ын хүний эрхийн нөхцөл байдал болон цаашдын хамтын ажиллагааны талаар ярилцлаа.

-Канад Улсын Элчин сайд Ж.Грегори Гөүлдхокийг хүлээн авч уулзаж Канад Улсад зохион байгуулдаг олон улсын хүний эрхийн хөтөлбөрт сургалтад ХЭҮК-ын ажилтанг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлэв.

-НҮБХХ-ийн Ази Номхон далайн бүсийн төвийн засаглалын асуудал хариуцсан зөвлөх Николас Бүүт, хүний эрх, засаглалын асуудал хариуцсан зөвлөх Ана Патрисиа нартай уулзаж уул уурхайн төсөл хөтөлбөр, хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад

хүний эрхэд үзүүлж байгаа сөрөг нөлөө, цаашид энэ салбарыг хүний эрх, байгаль орчинд хохиролгүйгээр хэрхэн хөгжүүлэх талаар ярилцаж санал солилцов.

- Эмнести Интернэйшнл байгуулгаас 8-р сарын 22-ны өдөр Монголын Эмнести Интернэйшнл байгууллагад үнэлгээ хийхээр ирсэн Хатагтай Уша Деви Комиссын даргатай уулзалт хийв.

-Мьянмарын ХЭҮК-ын дарга, гишүүд болон Рауль Волленбергийн Хүрээлэнгийн төлөөлөгчид Комисс дээр 2014 оны 9 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд айлчилж, Комиссын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах аялал зохион байгуулав. Өмнөговь аймгийн Даланзадгад сумд зохион байгуулсан Хүний эрхийн нээлттэй өдөрлөгтэй танилцах явцад Аймгийн засаг даргын орлогч болон ИТХ-ын дарга, Цагдаагийн Газрын дарга, ШШГА-ны удирдлагууд, олон нийт, иргэдтэй уулзалт хийв.

-Тайваны “Human Rights Protection Committee of Control Yuan” 11 дүгээр сарын 25-ны өдөр Комиссын дарга гишүүдтэй уулзалт хийлээ

Хүний эрхийн чиглэлээр олон улсын хурал зөвлөгөөн, сургалт, семинарт Комиссын Ажлын албаны ажилтнуудыг хамруулах боломжийг судалж гадаад улс оронд зохион байгуулсан 9 сургалтанд 11, давхардсан тоогоор нийт 17 ажилтныг гадаадад хурал, зөвлөгөөн сургалтад уригч талын зардлаар хамруулав. Үүнд:

- Ази Номхон Далайн Форумаас зохион байгуулсан Үр дүнтэй мөрдөн шалгалт явуулах нь сэдэвт холимог сургалтанд хэлтсийн дарга Б.Батаа
- Канадын EQUITAS байгууллагаас зохион байгуулдаг Олон улсын хүний эрхийн 35 дахь удаагийн сургалтад референт Ч.Ариунаа
- Эдийн засгийн хөгжлийн яамнаас ирүүлсэн албан тоотын дагуу Солонгосын олон улсын хамтын ажиллагааны агентлаг (КОИКА) “Хүний эрхийн бодлого төлөвлөлт” сэдэвт сургалтад Комиссын референт Ө.Ундрах, Э.Туул нар
- АНДЧ-наас ирүүлсэн ХЭҮБ-уудын ажилтнуудад зориулсан ахмад настны эрхийн асуудлаарх сургалтад БДШХЭБ-ын хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ
- Унгар улсад зохион байгуулсан эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаарх сургалтанд ахлах референт Ц.Адьяахишиг
- Женев дэх Фридрих Эбертийн Сангийн төв оффисоос олон улсын хүний эрхийн механизмын асуудлаар хийсэн сургалтад референт Э.Туул
- Солонгос улсын Чезүд болсон Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх, хамгаалах асуудлаарх сургалтад Комиссын референт Л.Дүгэрсүрэн
- АНДЧ болон Рауль Волленбергийн Хүрээлэнгээс хамтран зохион байгуулдаг ХЭҮБ-уудын ажилтнуудад зориулсан хүний эрхийн холимог сургалтад референт Б.Нандинцэцэг, З.Бадмаараг нар
- Швейцарь Улсын Женев хотноо болсон Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын олон улсын Зохицуулах Хорооны ээлжит XXVII хуралд референт Т.Ариунаа, Х.Цэцгээ нар
- Тайланд Улсын Бангкок хотноо 2014 оны 12 сарын 02-ноос 04-нд болсон Үндэсний хяналт, шалгалтын талаарх Дээд хэмжээний харилцан яриа-уулзалтад референт Ө.Ундрах, Т.Ихтамир нар
- Австрали улсын Сидней хотод болсон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх элчин сайдуудын уулзалтад БДШХЭБХ-ийн дарга Г.Агар-Эрдэнэ
- Данийн Копенгаген хотод зохион байгуулагдсан Хүний эрхийн боловсролын симпозиумд референт Б.Болорсайхан, нягтлан бодогч С.Нармандах нарыг тус тус оролцууллаа.

3.2 Дотоод хамтын ажиллагаа

Үндсэн хууль болон манай улсын нэгдэн орсон хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх, сахин хамгаалах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, урьдчилан сэргийлэх, таслан зогсооход хамтран ажиллах зорилгоор Монголын Сэтгүүлчдийн

эвлэлтэй хамтран ажиллах Санамж бичгийг 2014 оны 2 дугаар сарын 21-нд байгуулж ХЭҮК-ын дарга Ж.Бямбадорж, МСЭ-ийн ерөнхийлөгч Б.Галаарид нар гарын үсэг зурав.

Цэргийн алба хаахтай холбогдсон харилцаанд оролцогчдын эрхийг хангах, хамгаалах, тэр дундаа хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчдыг дүрмийн бус харьцааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэдний сахилга, хариуцлагыг сайжруулах, цэргийн алба хаагчдын хүний эрхийн болон хууль, эрх зүйн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх зорилгоор Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, дэслэгч генерал Ц.Бямбажав, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон харилцаанд оролцогчдын эрхийг хангах, хамгаалах, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, сахилга хариуцлагыг сайжруулах, цагдаагийн алба хаагчдын хүний эрхийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, байгууллагууд хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Цагдаагийн Ерөнхий Газрын дарга, тэргүүн комиссар С.Баатаржав, Иргэний болон Эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хангах, хамгаалах, түүний дотор хоригдсон, баривчлагдсан, цагдан хоригдсон хүмүүстэй хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлон харьцах явдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэдний сахилга, хариуцлагын тогтолцоог сайжруулах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, албан хаагчдын хүний эрх, хууль, эрх зүйн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, хоёр байгууллагын хоорондын хамтын ажиллагааг уялдуулан бэхжүүлэх зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа С.Баяндалай, Гэрч, хохирогчийг хамгаалах, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, яллагдагч, гэрчийг албадан ирүүлэх, ялтан шилжүүлэх, оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах, гэрч, хохирогч, яллагдагч, ялтнуудтай хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлон харьцах явдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, Тахарын албаны ажилтан, албан хаагчдын хүний эрхийн ойлголтыг дээшлүүлэх, байгууллага хоорондын хамтын ажиллагааг уялдуулан бэхжүүлэх зорилгоор Тахарын Ерөнхий газрын дарга, тэргүүн тахар Ц.Азбаяр нартай хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зурах ажиллагааг 2014 оны 11 дүгээр сарын 27-нд Комиссын байранд зохион байгуулав.

Өмнөговь аймгийн нийт иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор 2014-2016 онд хамтран ажиллах Санамж бичгийг 2014 оны 11 дүгээр сард аймгийн ИТХ-ын дарга Л.Батчулуунтай байгууллаа. Нийт Санамж бичгийн хүрээнд хамтран ажиллахаар 2015 оны төлөвлөгөөнд тусгасан.

Үйлдвэрчний эвлэлтэй хийсэн санамж бичгийн хүрээнд хөдөлмөрлөх эрхийн асуудлаар бүсчилсэн сургалт болон хүний эрхийн хамгаалагчдын асуудлаар хамтран судалгаа хийсэн.

Хүүхдийн төлөө Үндэсний Газрын дарга И.Нарантуяа, ХТҮГ-ын хүүхэд хамгаалал, үйлчилгээний газрын дарга Б.Жавзанхүү нартай 2014 оны 3 дугаар сарын 3-нд Комиссын дарга Ж.Бямбадорж, ХЭҮК-ын Ажлын албаны дарга А.Дашдэлэг нар уулзаж, хүүхдийн эрхийн асуудлаар цаашид хэрхэн үр дүнтэй хамтран ажиллах талаар ярилцаж хамтын ажиллагааг идэвхжүүлэв.

Орон тооны бус зөвлөлийн өргөтгөсөн хурлыг 2014 онд 3 удаа зохион байгууллаа. Хүний эрхийн Үндэсний Комиссын Орон тооны бус зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж 2014 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж байна. Хурлаас гарсан шийдвэрийн биелэлтийг ханган орон тооны бус зөвлөлийн гишүүдтэй байнга харилцан эргэх холбоотой ажиллаж байна. Мөн орон тооны бус зөвлөлийн гишүүдийн танилцуулгыг хэвлэн гаргаж, зөвлөлийн 2014 оны төлөвлөгөөг батлан гаргав.

Хүний эрхийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудын дунд уулзалт хэлэлцүүлэг 2 удаа зохион байгууллаа. Эхний буюу (8 дахь) уулзалтаар Комиссын "Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл"-ийг танилцуулав. Уулзалтыг 2014 оны 5 дугаар сарын 21-нд Төрийн ордонд Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд зохион байгуулсан бөгөөд нийт 68 иргэний нийгмийн байгууллагуудын

төлөөлөл оролцож, үзэл бодлоо илэрхийлж, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүд, УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны дарга болон бусад хүмүүстэй санал солилцов. (9 дэх) уулзалтыг 2014.12.19-нд Засгийн 11-р байрны дугуй зааланд зохион байгуулж ХЭҮК, ИНБ-ын 25 төлөөлөл оролцлоо. Уулзалтыг Комиссын дарга нээж, Ажлын албаны дарга А.Дашдэлэг “ХЭҮК-ын 2012-2014 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт”-ийн байдлыг танилцууллаа. ОТБЗ-өөс 3 гишүүн мэдээлэл хийв. Үүнд: “Хүний эрхийг хамгаалагчдын эрх ба олон улсын туршлага” Оюу Толгой Хяналт ТББ-ын тэргүүн Д.Сүхгэрэл, “Хүний эрхийг хамгаалагчид ба технологи” Эмнести Интернейшнлийн г/з Б.Алтантуяа, “Хүүхдийн эрх” Хүүхдийн эрх хамгаалал төвийн тэргүүн Л.Бадамцэцэг нар тус тус мэдээлэл хийж санал солилцов.

ДӨРӨВ. КОМИССЫГ ЧАДАВХЖУУЛАХ БЭХЖҮҮЛЭХ, ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1 Комиссыг чадавхижуулах, бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа

Ажлын албаны даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг “Комисст ажиллаж буй төрийн алба хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр 2014-2016 он”-ийг боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд 2014 онд 11 ажилтныг гадаадын оронд, 6 ажилтныг дотоодын сургалтад хамруулж, 2 ажилтанд орон сууцны хөнгөлөлтөд хамрагдахад дэмжлэг үзүүлсэн байна.

Комиссын ажилтнуудыг чадавхижуулах ажлын хүрээнд 2014 онд нийт 8 удаа дараах сэдвээр дотоод сургалт зохион байгууллаа. Үүнд: Албан хэрэг хөтлөлт сэдвээр АЕГ-аас 2014.02.21-нд, “Төлөвлөгөө, тайлан боловсруулах нь” сэдвээр Ажлын албанаас 2014 оны 4 дүгээр сарын 18-нд, “Судалгааны асуулга боловсруулах, мэдээллийг боловсруулах SBSS программ”-ын талаар анхан шатны мэдлэг олгох” сургалтыг 2014 оны 5 дугаар сарын 02-нд Хэвлэлийн хүрээлэнгээс, “Компанийн нийгмийн хариуцлага” сэдвээр 2014.06.13-нд СЗХ-ноос, “Харилцааны соёл”-сэдвээр Сэтгэл судлалын үндэсний хүрээлэнгээс, “Илтгэх урлаг” сэдвээр Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэнгээс тус тус багш урьж, мөн Комисст ажиллаж буй Австралийн сайн дурын ажилтан “Хүний эрхийн хамгаалагч”, “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь” сэдвээр 2 удаа сургалт зохион байгуулж, ажлын албаны нийт ажилтан хамрагдлаа. Нийт 22 цагийн хичээл зааж, Ажлын албаны ажилтнууд бүрэн хамрагдлаа.

АНДЧ болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэгээс хамтран зарлаж буй “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх элчин сайд” сэдэвт төсөлд Комиссын гишүүн П.Оюунчимэг, хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ нарын нэр дэвшүүлж холбогдох материал нэр дэвшигчийн “Зорилго мэдүүлэх захидал”, хэрэгжүүлэх төслийн зураглал төсөл, намтар болон Комиссын дарга нэр дэвшигчдийг дэмжиж байгааг илэрхийлсэн захидал боловсруулж хүргүүлэв.

Ажилтнуудын аюулгүй байдлыг хангах, үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Уулзалтын өрөөг тохижуулж, хяналтын камер, дуудлагын хонх, мэдээллийн самбар, хүүхдийн тоглоом, ном, ханын шүүгээ зэргийг байршуулав.

Төслийн үнэлгээ хийх ажлын хүрээнд Комиссын дарга, Ажлын албаны дарга нар НҮБХХ-ийн Суурин төлөөлөгч Сезин Синаноглу, Суурин төлөөлөгчийн орлогч Томас Эриксон нартай уулзалт хийж, хэрэгжиж дуусч байгаа төслийн үр өгөөж болон дараагийн төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой санал солилцов. Ирэх оноос хэрэгжүүлэх төслийн саналыг боловсруулж хүргүүлэв.

"Эрүү шүүлтийн эсрэг Элчин сайд"-аар ажиллахаар боллоо

Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудыг эгнээндээ нэгтгэдэг "Ази Номхон Далайн Хүний эрхийн Форум" болон Англид төвтэй "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ассоциаци" олон улсын байгууллагаас 2014-

2016 онд Ази Номхон далайн бүсийн Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын дунд "Эрүү шүүлтийн эсрэг Элчин сайд" сонгож ажиллуулах тухай хөтөлбөрийг 2015 онд хэрэгжүүлэх гэж байна.

Бүсийн 21 хүний эрхийн үндэсний байгууллагаас шалгаруулалт хийж, хүний эрхийн 7 байгууллагын 11 төлөөлөгчийг сонгон шалгаруулжээ.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн П.Оюунчимэг, ХЭҮК-ын Бодлогын дүн шинжилгээ, хүний эрхийн боловсролын хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ нар энэхүү шалгаруулалтад тэнцэж "Эрүү шүүлтийн эсрэг Элчин сайд"-аар 2014-2016 онд ажиллахаар болсон байна.

Зэвсэгт хүчний ардчилсан хяналтын Женевийн Төвийн албан ёсны гишүүнээр элсүүллээ

Зэвсэгт хүчний ардчилсан хяналтын Женевийн Төвөөс ШХУ-ын Женев хотноо 2014 оны 10 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд зохион байгуулж буй Зэвсэгт хүчний омбудсманы олон улсын 6 дугаар бага хуралд Комиссын гишүүн Пүрэвийн Оюунчимэг оролцож байна.

Уг хурлаар зэвсэгт хүчний байгууллагууд олон нийтийн хэвлэл мэдээллийг ашиглах нь; зэвсэгт хүчний омбудс байгууллагууд дахь олон нийтийн хэвлэл мэдээллийн үүрэг роль;; зэвсэгт хүчний дүр төрхийг төлөвшүүлэхэд омбудс байгууллагуудын гүйцэтгэх үүрэг; гомдол шийдвэрлэх механизмыг илүү үр дүнтэй болгох нь гэсэн 5 сэдвийн хүрээнд оролцогчид илтгэл тавьж, хэлэлцүүлэг хийх юм. Комиссын гишүүн П.Оюунчимэг "Гомдол шийдвэрлэх механизмыг илүү үр дүнтэй болгох нь" сэдвийн хүрээнд "ХЭҮК-ын гомдол шийдвэрлэх үйл ажиллагаа", "ХЭҮК болон Зэвсэгт хүчний жанжин штабын хамтын ажиллагаа" сэдвээр илтгэл тавьж оролцож байна.

4.2 Комиссын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн үйл ажиллагаа

Комиссын хурлыг 2014 онд 16 удаа хийж нийт 39 асуудал авч хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Комиссын 2014 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, сар бүрийн ажлыг төлөвлөн ажлын тайланг комиссын хуралд, Комиссын үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд БДШХЭБ-ийн хэлтсийн ахлах референт дотоод үнэлгээ, дүн шинжилгээ 3 удаа хийж, Ажлын албаны даргад тус тус танилцуулж ажиллав. Жилийн эцсийн үнэлгээгээр төлөвлөсөн 100 арга хэмжээнээс санхүүжилтгүйн улмаас хяналт шалгалтын 2, сургалт сурталчилгааны 4 арга хэмжээ хасагдаж, Комиссоос хамааралгүй 3 арга хэмжээ хойшлогдсон байна.

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 91 арга хэмжээний гүйцэтгэлийн биелэлтийн хувь дараах байдалтай байна. Үүнд:

- 100 хувийн биелэлттэй-78 арга хэмжээ
- 95 хувийн биелэлттэй-1 арга хэмжээ
- 90 хувийн биелэлттэй-7 арга хэмжээ
- 85 хувийн биелэлттэй-1 арга хэмжээ
- 80 хувийн биелэлттэй-4 арга хэмжээ

Комиссын 2014 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 98 хувьтай байна.

Комиссын нийт 49 албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөн, цалин хөлс, үр дүнгийн үнэлгээ зэрэг мэдээлийг шинэчлэн Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайлан гаргаж ТА3-д 2014.01.15-нд цахим хэлбэрээр хүлээлгэн өгсөн. Түүнчлэн Авлигатай тэмцэх газарт 2013 оны ХАСХ болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны нэрсийн жагсаалт, мэдүүлгийн тайлан ХАСХОМ-1, ХАСХОМ-2, ХАСХОМ-4 болон эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны тайланг хуулийн хугацаанд нь хүргүүллээ. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг нийт 46 албан тушаалтнаас хуулийн хугацаанд гаргуулж, бүрэн хамруулж, бүртгэлийг хөтлөсөн. ХЭҮК-ын авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөө гарган хэрэгжилтэд хяналт тавьж тайланг хугацаанд нь хүргүүлж үнэлүүлсэн болно.

Комиссын сар бүрийн төсвийн гүйцэтгэл, нийгмийн даатгалын тайланг холбогдох байгууллагад, төслийн сар бүрийн зарцуулалтын тайланг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн газарт хугацаанд нь хүргүүлж, төсвийн болон төслийн өдөр тутмын шаардлагатай гүйлгээг тухай бүр нь хийж гүйцэтгэсэн байна.

Төвд болон 21 аймагт 2014 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж, тавилга худалдан авах нээлттэй тендер шалгаруулалтыг явуулж, шалгарсан бэлтгэн нийлүүлэгч компанитай гэрээ байгуулан худалдан авах ажиллагааг хийж дуусгав. Хөрөнгө оруулалтаар хүлээн авсан тоног төхөөрөмжийг орон нутагт хүргүүлээд байна. Комиссын санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг хөтлөх, мэдээллийн технологийн төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж, дотоод сүлжээ, компьютер, хэвлэх төхөөрөмжид гарсан гэмтэл доголдлын талаарх нийт 500 гаруй дуудлага хүлээн авч дотооддоо цаг тухайд нь засч тохируулсан байна. Антивирусны програмын хугацаа дууссан 24ш компьютерт шинээр програм суулгасан байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг стандартын дагуу явуулж нийт ирсэн бичиг-531, өргөдөл гомдол-710-ыг хүлээн авч, хариутай албан бичиг 204, гомдол 685-ыг зохих журмын дагуу шийдвэрлэсэн байна. Комиссоос явуулсан 915 бичиг, 19 шаардлага, 25 зөвлөмж, 3 төлөөлөн нэхэмжлэлийг баримт бичгийн стандартын дагуу боловсруулан гаргаж, холбогдох 1145 байгууллагад хүргүүлж цахим бүртгэлд тэмдэглэл хийж хадгалсан байна.

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг 2014 оны 1-р улиралд боловсруулан батлуулж, Комиссын ажилтнуудаас архивт хадгалах 2013 оны баримтыг хүлээн авч, эмхэлж цэгцлэн, архивын байнга хадгалах -33, түр хадгалах- 20 хадгаламжийн нэгж бүрдүүлж, тоо бүртгэл хөтлөсөн. Мөн архивын баримтын мэдээ гаргаж, Архивын Ерөнхий газарт хүргүүлсэн болно.

Комиссын “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөө”-г 13 зорилтын хүрээнд 46 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллалаа. Төлөвлөгөөний биелэлт, тайланг төлөвлөгөөнд заасан үйл ажиллагааны зорилт бүрээр гаргаж хавсралт 98 хуудас баримтыг бүрдүүлэн тогтоосон хугацаанд нь хүргүүлж дүгнүүлсэн. Өнгөрсөн жил 43 оноо авч байсан бол энэ жил 62 оноотой дүгнэгдсэн. Энэ ажлыг дүгнэх үеэр Комиссын вэб сайт ажиллахгүй байсантай холбогдон газар дээр үзүүлж дүгнүүлэх ажлыг зохион байгууллаа.

Комисст шинээр томилогдсон орон нутгийн 21 ажилтан тус бүрд хувийн хэрэг нээж ТАЗ-өөс баталсан журмын дагуу бүрдүүллээ. Комиссын орон нутгийн ажилтныг албан өрөөтэй болоход дэмжлэг үзүүлэхийг нийт аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нарт албан бичгээр хүсэлт тавьж, ахлах мэргэжилтнүүд холбогдох хүмүүстэй уулзаж, тус бүрдээ өрөөний асуудлаа шийдвэрлүүлэв. Орон нутагт ажиллах 17 ажилтантай үр дүнгийн, 4 ажилтантай хөдөлмөрийн гэрээ мөн бүх ажилтнуудтай эд хөрөнгийн хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж байна.

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН АЖЛЫН АЛБА